



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХАРХОРИН ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 02 өдөр

Дугаар А/38

Хархорин

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, 59.1.12, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.4 дахь хэсэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны “Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээг эрчимжүүлэх, мал, амьтны шилжилт хөдөлгөөнд хяналт тавих, сэг зэм устгах тухай” 01 дүгээр албан даалгавар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2024 оны “Орчны бохирдлыг бууруулах, хуулийн хэрэгжилтийг хангах, эрчимжүүлэх талаар” Өвөрхангай аймгийн Засаг даргын “Бог малын гоц халдварт цэцэг өвчинтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай” 03 дугаар албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн үйл ажиллагааг 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрөөс 05 дугаар сарын 10-ны хооронд шуурхай зохион байгуулсугай.

2. Мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, орчны цэвэрлэгээ халдваргүйтгэлийг зохион байгуулах, отор нүүдэл, шилжилт хөдөлгөөнд хяналт тавих ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. Мал, амьтны сэг зэмийг цуглуулж, орчны цэвэрлэгээ хийхэд малчид, иргэдийг оролцуулж ажиллахыг бүх багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Улсын болон орон нутгийн чанартай зам дагуух болон цуглуулсан мал, амьтны сэг зэмийг булж устгахыг “Хархорин АЗЗА” ТӨХК-ийн захирал (Ч.Алтанбагана)-д даалгасугай.

5. Мал эмнэлгийн халдваргүйтгэлийн ажлыг Мал эмнэлэг, үйлчилгээний нэгжийн их эмч (Ц.Пүрвээ), (А.Сайнбилэг) нарт тус тус үүрэг болгосугай.

6. Мал, амьтны сэг зэмийг цуглуулж, булж устгах ажлын гүйцэтгэл чанарт хяналт тавьж ажиллахыг байгаль орчны хяналтын улсын байцаагч (Ц.Баатарсүрэн), мал эмнэлгийн тасгийн дарга (Э.Нарангарав) нарт тус тус даалгасугай.

7.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Лхагвасүрэн), уг ажилд шаардагдах зардлыг олгохыг нягтлан бодогч (О.Гангацэрэн) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ОДГЭРЭЛ

Хархорин сумын Засаг даргын 2024 оны
04 дүгээр сарын 02 өдрийн 001 дугаар
захирамжийн 1 дүгээр хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Гишүүд:

Б.Лхагвасүрэн (Засаг даргын орлогч)
Ч.Алтанбагана ("Хархорин АЗЗА" ТӨХК-ийн захирал)
Г.Лхагвабуд (Хотын захирагчийн албаны ерөнхий менежер)
Ц.Баатарсүрэн (Байгаль орчны асуудал хариуцсан
мэргэжилтэн)
Н.Төгөлдөр (Байгаль хамгаалагч)
С.Мөнхсоёл (Бэлчээр, газар тариалангийн асуудал
хариуцсан мэргэжилтэн)
Э.Үүрцайх (Мал, аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн)
Ц.Пүрвээ ("Дэлийн бүрд" мал эмнэлэг, үйлчилгээний
нэгжийн эмч)
А.Сайнбилэг ("Аяган зураа" мал эмнэлэг, үйлчилгээний
нэгжийн эмч)
Т.Алтангэрэл (1 дүгээр багийн Засаг дарга)
Р.Сүхбат (2 дугаар багийн Засаг дарга)
Д.Батчулуун (3 дугаар багийн Засаг дарга)
Г.Отгонбаяр (4 дүгээр багийн Засаг дарга)
Б.Ганхуяг (5 дугаар багийн Засаг дарга)
Л.Төгөлдөр (6 дугаар багийн Засаг дарга)
О.Батсүх (7 дугаар багийн Засаг дарга)
П.Нэндарам (8 дугаар багийн Засаг дарга)
Б.Пүрэвсүрэн (1 дүгээр багийн зохион байгуулагч)
Б.Сарангэрэл (2 дугаар багийн зохион байгуулагч)
Д.Хишигсүрэн (3 дугаар багийн зохион байгуулагч)

Нарийн бичгийн дарга: Э.Нарангарав (Мал эмнэлгийн тасгийн дарга)

Хархорин сумын Засаг даргын 2024 оны
 4 дүгээр сарын 2 өдрийн 4/38 дугаар
 захирамжийн 2 дугаар хавсралт

МАЛ, АМЬТНЫ СЭГ ЗЭМИЙГ ЦУГЛУУЛЖ УСТГАХ, ОРЧНЫ ЦЭВЭРЛЭГЭЭ
 ХАЛДВАРГҮЙТГЭЛИЙГ САРЫН АЯНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН
 ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Ажил үйлчилгээ	Хугацаа	Хариуцах эзэн	Хамтран хэрэгжүүлэгч
1. Удирдлага зохион байгуулалт				
1.1	Хорогдсон малын сэг зэмийг устгах, халдваргүйжүүлэх ажлын Засаг даргын захирамж гаргаж, төлөвлөгөө боловсруулж бүх нийтийн ажил болгон зохион байгуулах	4 дүгээр сарын 02-ны дотор	Э.Нарангарав	Засаг даргын Тамгын газар, "Хархорин АЗЗА" ТӨХК
1.2	Орчны цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйтгэл хийх мэргэжил арга зүй, зөвлөмж, удирдлагаар хангах, хяналт тавих	Тогтмол	Засаг даргын Тамгын газар	"Хархорин АЗЗА" ТӨХК, МЭҮНэгжүүд, Малчид
1.3	Эзэнгүй орхисон мал, амьтны хүүр, сэг зэмийн эх үүсвэрийг мөрдөн мөшгөж тогтоон, буруутай этгээдэд холбогдох хууль, журмын дагуу хариуцлага тооцох, үр дүнг тайлагнах	Тухай бүр	Ц.Баатарсүрэн	Малчид, иргэд
1.4	Бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулах	Улиралд 1 удаа	Ц.Баатарсүрэн	Хот тохиожолтын алба, иргэд
1.5	Хийж гүйцэтгэсэн ажлын тайланг заасан хугацаанд гаргаж ирүүлэх, нэгтгэж үр дүнг тооцон Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах	5 дугаар сарын 10-ны дотор	Э.Нарангарав	Засаг даргын Тамгын газар
2. Мал эмнэлгийн тасаг, Хөдөө аж ахуйн тасаг				
2.1	Отор нүүдэл шилжилт хөдөлгөөнд хяналт тавин ажиллах	Тогтмол	Э.Нарангарав Э.Үүрцайх	Мал эмнэлэг, үйлчилгээний нэгжүүд, Малчид
2.2	Мал, амьтны халдварт, гоц халдварт өвчний дуудлага, үйлчилгээний бэлэн байдлыг хангаж ажиллах	Тухай бүр	Э.Нарангарав	Мал эмнэлэг, үйлчилгээний нэгжүүд
2.3	Малын гоц халдварт, халдварт, шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээг технологит хугацаанд нь чанартай зохион байгуулах	Жилдээ	Э.Нарангарав	Мал эмнэлэг, үйлчилгээний нэгжүүд, Малчид
2.4	2024 оны халдваргүйтгэлийн төлөвлөлтийг мал эмнэлгийн нэгдсэн системд оруулах	4-р сарын 10-ны дотор	Э.Нарангарав	Мал эмнэлэг, үйлчилгээний нэгжүүд
2.5	Халдваргүйтгэлийн бодисын нөөц, хэрэглээ, чанар үр дүнд хяналт тавих	Тухай бүр	Э.Нарангарав	Мал эмнэлэг, үйлчилгээний нэгжүүд
2.6	Хээлтүүлэгч малын суурьт гоц халдварт, халдварт өвчний эмнэлзүйн үзлэг хийх, шаардлагатай тохиолдолд лабораторийн шинжилгээнд хамруулж баталгаа гаргах	Хагас жилдээ	Э.Үүрцайх Э.Нарангарав	Мал эмнэлэг, үйлчилгээний нэгжүүд, Малчид
2.7	Хорогдсон малын сэг зэмийг булж устгах устгалын цэгийн судалгааг гаргах	4-р сарын 02-ны өдрийн дотор	Э.Нарангарав	Багийн Засаг дарга нар
2.8	Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн боловсруулах, цуглуулах	Жилдээ	Э.Нарангарав	Мал эмнэлэг, үйлчилгээний

	үйлдвэр, түүхий эд бүтээгдэхүүний төвүүдтэй халдваргүйтгэл хийх гэрээ байгуулан ажиллах			нэгжүүд, Түүхий эдийн төвүүд
2.9	Цугларсан сэг зэмийг тогтоосон цэгт булж устгах	5 дугаар сарын 05-ны дотор	Засаг даргын тамгын газар	"Хархорин АЗЗА" ТӨХК, Малчид
3. Сургалт, мэдээ, мэдээлэл зөвлөмж хүргүүлэх				
3.1	Хуулийн хүрээнд мал, амьтан өмчлөгч этгээдийн үүрэг, хариуцлагыг тодорхойлсон зөвлөмж гарган хүргүүлэх	4-р сарын 20-ны дотор	Ц.Баатарсүрэн	Э.Нарангарав
3.2	Малчдыг мэдээ мэдээллээр хангаж, гарын авлага, шторк, сургалтын ажлыг үе шаттай зохион байгуулах	Тогтмол	Э.Нарангарав	Засаг даргын Тамгын газар
4. Өдөр тутмын мэдээ, мэдээлэл солилцох				
4.1	Улсын болон орон нутгийн чанартай авто зам дагуух сэг зэмийг цуглуулж устгасан мэдээг мэдээллэх	7 хоног бүрийн 3 дахь өдөр	"Хархорин АЗЗА" ТӨХК	Э.Нарангарав
4.2	Малын зүй бус хорогдол, сэг зэм устгал, халдваргүйтгэлийн явцын мэдээг загвар хүснэгтийн дагуу ирүүлэх	Тухай бүр	Э.Нарангарав	Багийн Засаг дарга нар, Хөдөө аж ахуйн тасаг